



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 8/215

Улаанбаатар хот

“Төрийн албан хаагчийн сургалтын  
хөтөлбөр” батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, тус Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын харилцааны салбарын “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Газрын харилцааны салбарын “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт суулгахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Л.Лувсан/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНХҮҮ



08 192081

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн  
газрын даргын 2019 оны 55.3 дугаар  
тушаалын хавсралт



## ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Газрын харилцааны салбар нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, технологийн, орон зайн мэдээллийн менежментийн талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зорилго, чиг үүрэг бүхий улс эх орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэгч салбар юм.


Тус салбарт суманд 361, аймагт 363, нийслэл, дүүрэгт 210, агентлагт 86, нийт 1020 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд эдгээрээс 129 ажилтан магистр зэрэгтэй бол үлдсэн албан хаагчид бакалавр, бүрэн болон тусгай дунд боловсролтой байна. Төрийн албанд орсноос хойш мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэх боломж багасдаг нөгөө талаас албан хаагчийг сургах чиглэлийн захиргааны санаачилга хангалттай хэмжээнд хүрэхгүй байна.

Төрийн шинэчлэлийн бодлогын хүрээнд байгууллагын стратегийн зорилт, чиг үүргийг мэргэшсэн, хөrvөх чадвартай хүний нөөцийн хүчээр хэрэгжүүлэх, нийгмийн хөгжлийн хурдац, үйлчлүүлэгчдийн өдрөөс өдөрт өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээнд нийцсэн үр дунд суурилсан төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, аливаа өөрчлөлтөд уян хатан, тасралтгүй суралцагч байгууллага, албан хаагчид нь мэргэшсэн чадварлаг байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Монгол Улсын Төрийн албаны тухай хуулиар төрийн жинхэнэ алба нь чадахуйн зарчимд үндэслэх, мэргэшсэн, тогтвортой байх, шатлан дэвших тогтолцоогоор ажиллахаар тогтоосон билээ. Төрийн албанд мэргэшсэн байхын нэг үндэс нь сургалт бөгөөд уг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт төрийн байгууллага нь “Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийн боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэс болж байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

2.1. Газрын харилцааны салбарын төрийн албан хаагчид буюу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын албан хаагчид, орон нутаг дахь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинэ мэдлэг чадвар бий болгох замаар мэргэшсэн, ур чадвар бүхий хамт олныг төлөвшүүлэн бүрдүүлэх, ажлын гүйцэтгэл, үр нөлөөг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.



2.2. Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

2.2.1. Төрийн албан хаагчийг богино болон дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамруулах;

2.2.2. Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах.

2.3. Хөтөлбөрийг 2020-2025 оны хооронд хэрэгжүүлнэ.

2.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

2.4.1. Улсын болон орон нутгийн төсөв;

2.4.2. Олон улсын байгууллага, гадаад улсын зээл тусlamж;

2.4.3. Бусад.

#### **Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагаа**

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Төрийн албан хаагчийг богино болон дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академитай хамтран хэрэгжүүлнэ:

3.1.1. Төрийн албананд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамруулах;

3.1.2. Холбогдох төрийн албан хаагчийг богино хугацааны зорилтот сургалтад хамруулах;

3.1.3. Холбогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамруулах;

3.1.4. Холбогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамруулах.

3.2. Төрийн албан хаагчийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.1. Төрийн албан хаагчдыг албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагад нийцүүлэх, тэдгээрийн мэргэжил, мэргэшил, ур чадвараа дээшлүүлэх чиглэлээр захиргааны санаачлага, дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийн асуудлыг удирдан зохион байгуулах чадварлаг багийг бүрдүүлэх;

3.2.1.2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон аймаг, нийслэлийн хэмжээнд ажлын байран дээр сурхад таатай орчныг бүрдүүлэх, сайжруулах, шинэ дэвшилтээ техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах;

3.2.1.3. Албан хаагчдын санал, хүсэлтэд тулгуурлан, байгууллагын боломж, нөхцөлд нийцүүлэн эрэмбэлж, шийдвэрлэдэг байх

3.2.1.4. Албан хаагчдад албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагтай баримт бичиг, материалын жагсаалтыг гаргаж, түүгээр албан хаагчдыг хангах.

3.2.2. Салбарын мэргэжилтэн бэлтгэж буй боловсрол, сургалтын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



3.2.2.1. Мэргэжлийн чиглэлээр магистр, докторын сургалтад хамрагдаж буй төрийн албан хаагчдыг аль болох ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр, зайгаар суралцах уян хатан нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

3.2.2.2. Салбарын хүний нөөцийн мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэгдэх нөхцөлөөр хангаж, суралцагч, төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадварыг бодитоор үнэлэх, ашиглах механизмыг нэвтрүүлэх;

3.2.2.3. Салбарын мэргэжлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох дотоодын их, дээд сургуулиудын бакалавр, магистр, докторын түвшний сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээг хийх, сургалтын агуулгыг практик амьдралтай холбох, хөтөлбөрүүдийн уялдаа, чанарыг сайжруулах;

### **Дөрөв. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. Шаардлагатай төрийн албан хаагчийг төлөвлөгөөний дагуу сургаж, тодорхой мэдлэг ур чадварыг эзэмшүүлснээр хариуцсан ажил, чиглэлээрээ мэргэшиж ажлын гүйцэтгэл, үр нөлөө нь дээшилж, албан тушаалд мерит зарчмыг баримтлан томилж, дэвшүүлдэг, чадварлаг хүний нөөц бүхий хамт олон бүрдсэн байна.

4.1.2. Төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийн асуудлыг хариуцсан баг бүрдэж, багийн үйл ажиллагаа тогтворжсон байна.

4.1.3. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон аймаг, нийслэлийн хэмжээнд сургалтын өрөө тасалгаа бий болж, шаардлагатай сургалтын материал, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

4.1.4. Холбогдох их дээд сургуулиудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, хамтын үйл ажиллагаа өргөжсөн байна.

4.1.5. Хүний нөөцийн програм хангамж, мэдээллийн сан бий болж, мэдээлэл тогтмол шинэчлэгдэг болсон байна.

4.1.6. Их дээд сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөрт дүн шинжилгээ хийгдэж, дүн шинжилгээний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

4.1.7. Магистр, докторын зэрэгтэй ажилчдын тоо нэмэгдсэн байна.

4.1.8. Гадаадын их дээд сургуульд суралцаж буй албан хаагчдын тоо нэмэгдсэн байна.

4.2. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилт, түүнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг жил бурийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтээр үнэлэх бөгөөд албан хаагчид уг төлөвлөгөөнд заагдсаны дагуу шат дараалсан сургалтад хамрагдсан байна.

### **Тав. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт**

5.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар гүйцэтгэнэ.



5.2. Хөтөлбөрийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын албан хаагчид, орон нутаг дахь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид хэрэгжүүлнэ.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн болон тухайн жилийн төлөвлөгөө шаардлагатай бол төсөл, дэд хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлж болно.

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.2. Шаардлагатай тохиолдолд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа үр дүнд суурилсан явцын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно.

6.3. Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

